



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/192

Хэрлэн сум

Ур чадварын нэмэгдэл нөхөн олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын аймгийн Засаг даргатай байгуулсан 2016 оны жилийн эцсийн ажлыг үнэлсэн Боловсрол, соёл, урлагийн газрын дүгнэлтийг үндэслэн Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Ж.Алимантуяа, 8 дугаар цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан С.Оюунгэрэл нарт ур чадварын нэмэгдлийг 20 хувиар тооцон нөхөн олгосугай.

2. Цэцэрлэгийн эрхлэгч нарын ур чадварын нэмэгдлийг жилийн төсөвт багтаан тухайн албан тушаалыг эрхэлж байсан хугацаанд, жинхэнэ ажилласан цагт ногдох албан тушаалын цалингаас тооцож олгохыг цэцэрлэгийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 942